

**ДАНДАР АГРАМБА ҮНЭХЭЭР ЭС БҮТЭХҮЙ БОЛОН ШҮТЭН
БАРИЛДАХУЙН ЗАРЧМЫГ ТАЙЛБАРЛАСАН НЬ**
(*rTen 'brel snying bo'i dgongs 'grel* зохиолын жишээн дээр)

Б.Ариунзул – ШУА. ФСЭЗХ-ийн ЭША. магистр

Товч утга Монгол газар буддын гүн ухааныг түгээн дэлгэрүүлэх, түүний нарийн төвөгтэй асуудлуудыг нарийвчлан боловсруулахад өөрсдийн хүч хөдөлмөр, оюун ухаанаа зориулсан эрдэмтэн мэргэдийн нэг бол монголын шашин соёлын томоохон зүтгэлтэн, нэрт гүн ухаантан, олноо Дандар аграмба хэмээн алдаршсан Шадавдандар /1835-1916/ юм. Тэрээр эртний Энэтхэгээс улбаатай мадхьямака философи, ялангуяа түүний нэн нарийн чиглэл болох прасангика ёсны томоохон төлөөлөгчдийн нэг¹⁸ бөгөөд “Шүтэн барилдлагын зүрхэний тааллын тайлбар” /*rten 'brel snying ba'i dgongs 'grel thar ba'i 'jug ngogs*/ зохиолдоо үнэхээр эс бүтэхүй, шүтэн барилдахуй хэмээх мадхьямака философийн үндсэн хоёр зарчмыг удирдлага болгон юм үзэгдлийн нарийн утга учрыг хэрхэн ухаарч болох талаар өөрийн гэсэн үндэслэлүүдийг дэвшүүлжээ. Чухам ямар ямар үндэслэлүүдийг дэвшүүлсэн талаар үүнээ өгүүлсү.

Дандар аграмба, зохиолын товчоон

Монгол туургатны уламжлалт соёлын нэгэн бүрэлдэхүүн хэсэг болсон монголын буддизмын баялаг өв санг өөрийнх нь утга, агуулгын үүднээс танин мэдэх, судалж эзэмших эрмэлзэл идэвхжиж буй эдүгээ цагт өнөөгийн нийгэм, оюун санааны хөгжлийн өндөрлөгөөс урьдчилан тогтоон барьсан үзэл онолын үүднээс бус буддизмыг өөрийнх нь үндсэн онол, арга зүйн үүднээс судлан шинжлэх явдал чухал юм. Түүхэн хөгжлийн явцад боловсорч буй болсон буддын гүн ухааны сэтгэлгээ нь монголын нийгмийн оюун санааны амьдралд үлэмж нөлөө үзүүлж олон үеийн турш уламжлагдан баяжигдсаар монголын буддизм гэж нэрийдэх болтлоо үндэсний хэв шинжийг олсон ажгуу. Монголын буддизмын өөрийн гэсэн онцлог шинжүүдийг бүрэлдэн бий болоход, цаашлаад монголчуудын оюуны амьдралд жинтэй хувь нэмэр оруулсан томоохон мэргэдийн нэг нь даруй Дандар аграмба мөн болно.

Дандар аграмба 1835 онд Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошуунаа (одоогийн Булган аймгийн Хутаг-Өндөр сум) мэндэлжээ. Тэрээр бага наснаасаа эрдэм номын мөр хөөж, Их Хүрээнд гавжийн болон аграмбын дамжаа барьсан мэргэжлийн гүн ухаантан байсан ба гүн ухаан, дуун ухаан, анагаах ухаан, нийгэм-улс төр, ёс зүйн чиглэлээр 70 гаруй бүтээлийг туурвисан нь 3 боть болон эмхлэгдсэн байдаг¹⁹.

Үүнийг нягтлан үзэхүл, орчлон ертөнцийн тогтоц бүтэц, түүнийг танин барихуйн арга зам, хэлбэрийн тухай буддын гүн ухааны үзэл сургаалыг өргөн дэлгэр, гүн нарийн утгаар тусган илэрхийлсэн нэгэн сэдэвт бүтээл байхын зэрэгцээ Энэтхэг, Төвд орны их мэргэдийн ном сударт хийсэн үг, утгын тайлбар; санскрит, төвд хэлнээс эх хэл дээрээ хөрвүүлсэн орчуулга; уг, утгын дохионы бичиг; эм эмнэлгийн ухааны зохиолуудад хийсэн нэмэлт тайлбар зохиолууд ч байна. Иймд мэдлэгийн өргөн цар хүрээг хамарсан түүний бүтээлүүд нь уламжлалт түүх соёл, мэдлэг ухаанаа таньж мэдэхэд гол судлагдахуун эх сурвалж болох тухай дор тодруулмуй.

Дандар аграмба “Номлохуй ухааны товч үгсийн тайлбар” /*rtags rigs sdom rshig gi 'grel ba rigs lam gter gyi lde mig*/ хэмээх зохиолдоо өөрийн логик, танин мэдэхүйн онолын үзлээ

¹⁸ Монголын философийн түүх, IV дэвтэр, УБ., 2001, 364 дэх тал

¹⁹ Дандар аграмбын 3 боть бүрэн зохиол нь Дайчин вангийн хүрээнд модон бараар хэвлэгдсэн ба УНС, Гандантэгчэнлин хийдийн номын санд тус тус бүрэн эхээрээ хадгалагдаж байна. Мөн түүний бүрэн зохиолын эмхтгэлийг Энэтхэгийн эрдэмтэн Lokesh Chandra 1982 онд Делид хэвлүүлжээ /Lokesh Chandra, Works of Bstan-dar Snags-rams-pa. Sata-pitaka Series. Volume 291. Delhi, 1982/.

илэрхийлсэн байдаг. Монголын гүн ухаантан, логикч Шижээ Агваандондов “Нотлохуй ухааны товч үгс гучит” /tags rigs kyi sdom rshig sum cu ba/ нэртэй логикийн бие даасан бүтээлээрээ алдартай. Түүний энэ зохиолд Төвд, Монголын мэргэдийн туурвисан олон тайлбар байдгаас Дандар аграмбын тайлбар хамгийн дорвитой нь бөгөөд уг зохиол нь монголчууд буддын логикийг онолын өндөр түвшинд хэрхэн судалж, хөгжүүлж байсныг илтгэхүйц бүтээл юм.

Монголчууд бүр XIII зууны үеэс хэл шинжлэл нэн ялангуяа толь бичиг судлал, нэр томъёо судлалыг хөгжүүлж ирсэн уламжлалтай билээ. Түүний үр дүнд монголын төдийгүй дэлхийн соёлын түүхэнд гүнзгий ул мөрөө үлдээсэн “Зүрхэн толь”, “Мэргэд гарахын орон” зэрэг алдарт бүтээлүүд төрөн гарсан байдаг. Дандар аграмба нь зөвхөн гүн ухаантан байгаад зогсохгүй тухайн үеийнхээ эрдэм ухааны оргилд гарсан хүний хувьд томоохон хэл шинжээч байсан юм. Түүний туурвисан “Гүйцэтгэлийн доторхи хоёр хэлийг хослуулан найруулахуйн завсарыг барилдуулах ёс” /han thabs kyi klad kyi skad gnyis shan sbyar gyi mtshams sbyar tshul legs bshad me long/, “Мадхьямакийн шинжлэлээс гарсан үг бүтээхүйн өнцгийн чимэг” /dBu ma'i mtha' dpyod las byung ba'i sgra sgrub kyi zur rgyan blo gsal mig 'byed/ бүтээлүүд нь Дандар аграмбыг эртний гүн ухаан, утга зохиолын хэл болох санскрит хэлийг онолын түвшинд хэрхэн эзэмшсэнийг гэрчилдгээс гадна харьцуулсан хэл шинжлэл, философийн нэр томъёо судлалд чухал хувь нэмрийг оруулсныг нь нотолдог. Тэрээр эдгээр зохиолдоо анагаах ухааны болон мадхьямака философийн санскрит, төвд нэр томъёонуудыг харьцуулан шинжилсний үндсэн дээр ерөнхий нэр томъёо судлалын шинжтэй чухал дүгнэлтүүдийг хийсэн байдаг.

Дандар аграмбын хийсэн нэг томоохон зүйл бол орчуулгын зохиол дахь хэвлэлийн, бас утгын сэжгийг тодруулах, нарийвчлан шүүх, ариутгах ажлыг эрхлэн гүйцэтгэж байсан явдал юм. Энэхүү ариутгалаас “Ганжуурын”²⁰ адил бус хэвлэлүүдээс тасарсан, илүүдсэн буйд тоо, тэмдэг бичих нь” /bka' 'gyur gyi par mi 'dra ba chad lhag 'byung ba la ang rtags bri ba/²¹ хэмээх бүтээл нь судлаачдын анхаарлыг ихээхэн татаж буй бөгөөд эл бүтээлийн талаар академич Ц.Дамдинсүрэн «Ганжуурын олон хэвлэлүүдийг харьцуулан судалж зөв эхийг тогтооход Дандарын ариутгал чухал ач холбогдолтой бүтээл юм»²² хэмээн үнэлсэн байдаг. Тэрээр мөн Төвдийн эрдэмтэн Дармаринчэнгийн (1364-1432) бичсэн “Шалгадаг судрын тийн номлол” /Tshad ma mdo'i nam bshad/ хэмээх шалгадаг ухааны томоохон тайлбар бүтээлийн утгын болон хэвлэлийн алдааг ариутган шүүсэн юм²³.

Монголчууд Манжийн ноёрхлын эсрэг эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө эрслэн боссон XIX-XX зууны зааг үед Дандар аграмба амьдарч байсан юм. Тэрээр мэдлэг ухааны өргөн цар хүрээтэй эрдэмтэн хүний хувьд оршин амьдарч буй цаг үе, нийгэм-улс төрийн амьдралынхаа талаар өөрийн бодол санааг илэрхийлж байсан нь зүйн хэрэг. Энэ ч үүднээс

²⁰ “Ганжуур” нь эртний Энэтхэгийн шашин, гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээний сонгодог эх сурвалжуудын төвд орчуулгын эмхтгэл бөгөөд анх XI зууны үед Төвдийн Нартан хийдэд нийт 108 боть болон хэвлэгджээ. Үүнээс хойш 1000 шахам жилийн хугацаанд Жонэ, Дэргэ, Бээжин, Их Хүрээ зэрэг нийт 20 гуруй газар хэвлэгдсэн бөгөөд Дандар аграмба эдгээр хэвлэлүүдийг зарим санскрит эх болон Данжуур дахь тайлбаруудтай нь харьцуулан шүүж Ганжуурын сонгомол эхийг олж тогтоохыг зорьж байжээ.

²¹ mDo mang skor, dKon brtsegs kyi skor, Sher phyin gyi skor, Phal chen gyi skor гэсэн дөрвөн дэвтэр бүхий эл ариутгал бичгийн Винайн аймгийн 1000 гаруй хуудас үрэгдсэнийг 1970-аад оны үед номч мэргэн гавж С.Гомбожавын удирдлагаар Гандантэгчэнлин хийдийн Номын гэрийн хэсэг эрдэмтэн лам нар гүйцээжээ.

²² Ц.Дамдинсүрэн, “Ганжуурын төвд хэвлэлүүдэд хийсэн Дандар аграмбын ариутгал” – Монгол судлал, Том IX (17), Fasc. 2, УБ., 1982, 35-45 дахь тал

²³ Tshad ma mdo'i dar tika bkra shes lhun po dang sku 'bum par ma gnyis kyi yig skyon 'dogs byed nor bu ke ta ka нэртэй эл ариутгал бичиг “Лавайн эгшиг” сэтгүүлийн 1996 оны № 2-д нийтлэгджээ.

Дандар аграмба XVIII зууны үед Монголын томоохон эрдэмтэн лам нарын дунд үүссэн бурханы шашныг ариунаар мандуулах урсгалын гол төлөөлөгчийн нэг байсан ба шашны хямрал, хутагт хувилгаад болон ихэс лам нарын ёс суртахууны ялзрал доройтлыг хурцаар шүүмжилж, түүнийг сохроор бишрэн дагаж байгааг зогсоохыг уриалж байжээ. Мөн шашин номын цалгай явдалтныг төдийгүй, тэдэнтэй сүлбэлдэн зальхай бүхнийг үйлдэж буй ноёд, түшмэдийн арга баширыг илчлэн шүүмжилж байсан нь түүний “*Үг утга нь тодорхой цадигийн тайлбар*” /*ṁam thar gsal don gsal gyi ṁam bshad `chal sbyod dug can tsher ma phye mar `tag pa`i rdo rje me stag*/ зохиолд тодорхой тусгагдсан буй²⁴.

Шадавдандар “Суртгаалыг огоот суртахуйн гурван суурийн сэжгийг таслахуй” /*bslab pa yongs su sbyong ba`i gzhi gsum gyi dogs dpyod*/ зохиолдоо винайн ёсон дахь *сожон*, *ярнай*, *гэгээ* хэмээх ёс суртахууны шинжтэй *гурван суурь* зан үйлийн утга агуулгыг буддын философийн суурь онолын үүднээс магадлан шинжилсэн нь түүнийг ёс зүйн онолч байсныг гэрчилдэг. Тэрээр мөн “*Төв үзлийн үзэгдэл хэмээгдэхийн тэмдэглэл*” /*dbu ma snan ba`i brjed tho*<sup>25</sup>, “*Гайхамшиг болсныг сайтар номлосны үгийн тайлбар*” /*phul byung legs bshad ma`i tshig `grel*/, “*Нууц хураангуй үндэсийн утгыг машид ялгах газрын хуваар, их эрдэнийн түлхүүр*” /*gsang `dus rgyud kyi don ṁam par `byed pa`i sa bcad rin chen lde mig*/, “*Магад гарахуйг магтсан, эндүү үзэгдлийг таслах алтан хяргуур*” /*nges `byung la bstod pa snang shas gcod pa`i gser gyi spu gri*/ зэрэг гүн ухааны алдартай бүтээлүүдийг туурвисан болно.

Дандар аграмбыг мадхьямака философи, ялангуяа түүний нэн нарийн чиглэл болох хэтрүүлэгч төв үзлийн томоохон төлөөлөгчийн нэг хэмээн судлаачид үнэлсэн нь²⁶ оргүй зүйл биш ээ. Учир нь тэрээр “*Каиьяана бээр айлтгасан бүлэгээс* номлосон мадхьямакийн мөрийг тодорхойяа дуурсгах хурмастын их инээд” /*od srungs kyis zhus pa`i le`u nas gsung ba`i dbu ma`i lam gsal bar sgrog pa`i `phrog byed dbang bo`i gad rgyangs*/, “*Шүтэн барилдлагын магтаалын тайлбар цөөн үгт, тодорхой утгат*” /*rten `brel bstod pa`i grel ba tshig nyung don gsal*<sup>27</sup>, “*Шүтэн барилдлагын зүрхэний тааллын тайлбар*” /*rten `brel snying ba`i dgongs `grel thar ba`i `jug ngogs*/ зэрэг зохиолдоо мадхьямака философийн гол гол зарчмуудыг удирдлага болгон юм үзэгдлийн дотоод мөн чанар, нарийн шүтэлцээг тайлбарласан өөрийн гэсэн үндэслэлүүдийг дэвшүүлсэн байдаг.

Дандар аграмба Монголын алдарт гүн ухаантан Агваанбалдан (1797-1864), нэрт логикч Шижээ (XVIII зуун) нарын шавь байсан төдийгүй өөрөө түүхч, гүн ухаантан Зава Дамдингийн (1867-1937) багш, Чин Ван Ханддоржийн (1869-1914) зөвлөх байсан юм. Мөн XIII Далай лам Түвдэнжамц 1904 онд Их Хүрээнд ирэхдээ Дандар аграмбад шавь орж байжээ²⁸.

²⁴ Монголын философийн түүх, IV дэвтэр, УБ., 2001, 361-364 дэх тал

²⁵ Энэ зохиол Дандар аграмбынх мөн эсэх нь эргэлзээтэй. Учир нь тус зохиолын төгсгөл нь дутуу бөгөөд зохиогчын нэр байхгүй, түүнчлэн монголын буддизмын уламжлалд тус зохиолоос иш татахдаа Шижээ гэвшийн нэрээр ишэлдэг байжээ. Ер Дандар аграмбын сүнбумд орсон зохиол болгоныг түүнийх хэмээн тооцож болохгүй юм. Учир нь Агваанхайдавын “Үг, утга нь тодорхой цадиг”, Шижээ Агваандондовын “Нотлохуй ухааны товч үгс гучит”, “Шалгадгийн шүнг уншихуй дор чухал хэрэгтэй товч үгс” зэрэг зохиолууд түүний сүнбумд орж хэвлэгджээ. Харин энэ зохиолыг проф. Д.Дагвадорж “Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг” (УБ., 1998) бүтээлдээ Дандар аграмбын философийн гол бүтээл хэмээн судлан тайлбарласан буй.

²⁶ Монголын философийн түүх, IV дэвтэр, УБ., 2001, 364 дэх тал

²⁷ Тус зохиолыг доктор Т.Булган монгол хэлнээ орчуулан “Эрдэнийн түлхүүр” сонинд нийтлүүлжээ.

²⁸ Ж.Болдбаатар, Далай ламын монгол багш, УБ., 1995; Ц.Дамдинсүрэн, Өвгөн Жамбалын яриа, Түүвэр зохиол, УБ., 1969

Үнэхээр эс бүтэхүй, шүтэн барилдахуй

Энд Дандар аграмбын “Шүтэн барилдлагын зүрхний тааллын тайлбар, тонилохуйд орох олом” зохиолыг тухайлан авч үзэж буй бөгөөд энэ нь түүний ертөнцийг үзэх үзлийг илтгэсэн олон чухал эх сурвалжийн нэг юм. Тэрээр эл зохиолоо мадхъямака философийн арга зүйг баримтлан туурвижээ. Түүний сүмбүмийн “Kha” ботид орсон тус бүтээл нь Дайчин вангийн хүрээний модон бараар барлагдсан, 48х9 см хэмжээтэй, нийт 9 хуудас бүхий бөгөөд дотоод бүлэг зүйлийн хуваарилал байхгүй болно. Эл тайлбар зохиолын үндсэн эх судлагдахуун болох *rTen 'brel snying bo* буюу Шүтэн барилдлагын зүрхэн хэмээх алдарт зохиолыг Нагаржунагийн шавь Арьядэва зохиосон бөгөөд хэлмэрч Давашону төвд хэлнээ орчуулсан хэмээн Будон чойнжунд мэдээлжээ²⁹.

Аливаа шинжлэх ухаанд өөр өөрийн судалгааны төрөл, чиглэл болон судлагдахууны онцлогоос хамааран бие биеэс ялгагдах онолын зарчим, хууль, категори гэж буй бөгөөд үүгээрээ ч өөр хоорондоо харьцангуйгаар адилсаж, бас ялгарна. Философид ч нэгэн адил ямарваа асуудлуудыг чухам ямар хүрээ, түвшинд хэрхэн яаж гарган тавьж, шийдвэрлэхийг тодорхойлж байдаг онолын зарчим гэж бий. Энэ үүднээс буддын философийн нэг үндсэн чиглэл болох мадхъямака философид суурь онолоо тодорхойлж байдаг үнэхээр эс бүтэхүй, шүтэн барилдахуй гэсэн тулгуур хоёр зарчим³⁰ яригддаг. Эдгээр нь өнгөц ухаарахуйд ялгаатай мэт боловч цаад агуулгаараа хоорондоо салшгүй, нэг зүйл /хоосон чанар/-ийн утгыг илэрхийлэх хоёр тал болно. Үүнийг буддын судлалч эрдэмтэн мэргэд өөрсдийн зохиол бүтээлдээ буддын философийн тулгуур категориудаар илэрхийлэн харуулдгийн адил Дандар аграмба тус зохиолдоо “өөрийн эрхэт”, “бусдын эрхэт”, “мөнх бус”, “би үгүй” гэсэн ойлголтуудаар дамжуулан тайлбарласан байдаг. Тухайлбал, «Ном алин шалтгаанаас гармуй хэмээвээс хуран үүдсэн зовлонгийн мөн чанар, чухал авсан цогц нугууд үйл нисванисын бусдын эрхт бөгөөд агшин ч орших өөрийн эрхт үгүйг номлосон»³¹ хэмээснээс үзвэл нэгэнт бидний сэрэл, хүртэхүйд өгөгдөгч юм үзэгдлүүдэд өөр өөрийн онцлог шинж чанарууд бодитой байвч тэдгээр нь өөрийнхөө мөн чанараар бие дааж үнэхээр бүтсэн биш, харин зөвхөн бие биеэсээ харилцан шалтгаалцсан, шүтэн барилдсан байдлаар харьцангуйд орших учраас, түүнчлэн тэдний түрдэхүй, төрөхүй гэж үнэхээр бүтээгүй учраас мэдрэхүйн юм үзэгдэл өөрөө үнэхээр бүтээгүй байдаг гэдгийг илэрхийлсэн байна. Мөн «Ном бүгд шалтгаан үйлийн хувь хэсэг тул шүтээн ч мөн чанараар бүтэх үгүй»³² гэснээс үзэхэд хамаг номууд мөн чанараараа үгүй гэдэг бол тэдгээрийн харьцангуй бодитой оршин буйг үгүйсгэж байгаа хэрэг биш. Өөрөөр хэлбэл, бидний сэтгэл ухамсраас үл хамаарах мэдрэхүйд өгөгдөгч эмпирик тодорхой юм үзэгдлүүд оршин байгааг, бидэнд хүртэгдэж мэдэгдэж байгааг нь үгүйсгэж байгаа хэрэг огт бус. Гагцхүү тэгш оршин байгаа үзэгдэл юмс нь мөн чанараараа л үнэхээр бүтээгүй гэдгийг, тэр бүхэнд юмсын би ч үгүй буюу үнэхээр бүтсэн туйлын мөн чанар гэж үгүй гэдгийг тодорхойлж байгаа юм. Энэ утгаараа тэдгээр нь өөрийн мөн чанар үгүй болно. Ингэснээр энэхүү “мөн чанар үгүй” гэдэг нь цаад агуулгаараа мэдрэгдэн хүртэгдэгч юмсын оршихуйн асуудал, тэрхүү оршихуйн уг чанарын тухай асуудал болж тавигдана.

Энэ талаар «Хамаг ном мөн чанар үгүй хэмээх нь гурван зүйл энэ мэт буюу. Бэлгэ чанар мөн чанар үгүй хийгээд төрөхүйн мөн чанар үгүй ба үнэмлэхүйн мөн чанар үгүйгээс гарч хамаг номууд мөн чанар үгүй буюу хэмээн үзүүлсэн болой»³³ хэмээн “мөн чанар үгүй”

²⁹ Bu ston rin chen grub, *Bu ston chos 'byung*, Drepung Loseling Library Society, Delhi: 1996, 233 дахь тал

³⁰ Эл хоёр зарчмыг академич Г.Лувсанцэрэн багш “Төв үзлийн философийн онолын үндэс” (УБ., 2006) бүтээлдээ хоосон чанарыг тодорхойлогч суурь зарчим болохынх нь хувьд тодорхой нягталсан буй.

³¹ *rTen 'brel snying bo'i dgongs 'grel*. bsTan dar snags rams pa'i gsung.bum, Kha боть, 5 дахь хуудас, дээд

³² Мөн зохиол. 7 дахь хуудас, дээд

³³ “Хутагт тааллыг магад таалахуй”, Монгол Ганжуур, 64 дүгээр боть, 21 дэх хуудас, дээд

хэмээх ойлголтыг гурван үндэслэлээр тодорхойлж илэрхийлсэн байдаг. Үүнд “бэлгэ чанар” гэдэг нь аливаа юмсын тодорхой, онцгой шинж³⁴, “төрөхүй” гэдэг нь юмсын уг гарал, эхлэл³⁵ болно. Ингэхээр нэгж тодорхой юм үзэгдлүүдийн хүртэгдэн мэдэгдэгч тодорхой шинжүүд нь мөн чанараараа мөнхөд бүтчихсэн зүйл биш. Учир нь аливаа нэг зүйлийг нөгөөд нь харьцуулан нэрлэж тодорхойлохоос мөнхөд тэр чанараар өөрөө бүтсэн нь үгүй. Үүнд хүртэгдэгч юмсын тодорхой шинж бүхэн зөвхөн харьцааны хүчинд олддог *нэрийтгэлийн төдий* юм гэсэн утга байна. Үүнтэй холбогдож тодорхой юм үзэгдлүүдийн үүсэх, эвдрэх үйл явцыг авч үзэх хэрэгтэй болно. Үзэгдэл юмсын оршихуйн зөвхөн нэг агшныг нь бусдаас салган тогтоон барьж туйлшраад үүсэл гэж үздэг нь ташаарал гэж мадхьямака философид үздэг. Учир нь үүсэл гэдэг бол зөвхөн нэрийтгэлийн зүйл юм. Өөрөөр хэлбэл үүдэхүй хэмээх юмсын үнэмлэхүй биеэ даасан шинж гэж байхгүй. Учир нь юмсын үүдэхүй хэмээх тэр үйл явц өөрөө биеэ даасан үнэхээр бүтчихсэн туйлын зүйл биш гэж үзнэ. Дээрх үндэслэлд тулгуурлан юмсын “үнэмлэхүй мөн чанар” гэж үгүй хэмээх үзэл урган гарна. Нэг талаас хамаг ном (дхарма) төрөөгүй бас түрдээгүй. Нөгөө талаас түүний бэлгэ чанар бүхэн нь мөн чанаргүй. Өөрөөр хэлбэл тодорхой шинж бүхэн нь үнэхээр бүтээгүй. Тэгэхээр түүнд ямарваа “үнэмлэхүй мөн чанар” гэж байхгүй болно. Энэ бол юмсад ямарваа ашид тогтсон мөнхийн зүйл гэж огт байхгүй гэдгийг л хэлж буй юм.

Дандар аграмба номыг (дхармыг) *шалтгаан үйлийн хувь хэсэг* гэсэн нь цаанаа юмсын төрөх, түрдэх, буй, буй үгүйн шалтгаалцлын асуудлыг хөндөж, мэдрэхүйн юм үзэгдэл дотор ямар нэгэн үнэмлэхүй туйлын мөн чанар гэж байхгүй гэдгийг л тодорхойлж буй юм. Үүний сацуу юм үзэгдлийн үүсэх, эвдрэх үйл явцыг үгүйсгэж үл болох, тэр үйл явц бодитой байгааг хүлээн зөвшөөрөх ёстойг мөн давхар нотлон харуулж, гүн утга агуулгатайгаар хураангуйлан илэрхийлжээ.

Цаашлаад тус зохиолд «Ном алин шалтгаанаас гарна хэмээвээс зовлонгийн үнэн үгүүд мөнх бус, бусдын эрхэт, би үгүйг номлосон»³⁶ хэмээн буддын философийн гол гол ойлголтуудаар *үнэхээр эс бүтэхүйн* зарчмын агуулгыг гүнзгийрүүлэн тайлбарласан байдаг. Тухайлбал, төв үзлийн философийн гол категори болох “би” нь аливаа юмны өөрийн чанар³⁷ байгааг илэрхийлдэг. Үүний нөгөө талд аливаа юмны өөрийн чанар гэж үгүй гэсэн утга санааг илэрхийлдэг “би үгүй” хэмээх ойлголт гарч ирдэг бөгөөд энд аливаа ном шалтгаанаас гарахын учир нь аливаа номонд эгнэгт бүтчихсэн өөрийн чанар үгүй буюу “би үгүй” учраас гэсэн үндэслэлийг Дандар аграмба гаргаж ирсэн байна. Өөрөөр хэлбэл аливаа юм бусдаас ялгагдаж бие даан оршин байхын сацуу оршихгүйгээрээ мөн тодорхойлогддог, ингэснээрээ орших, эс оршихын заагт *нэрийтгэлийн төдий* буй гэсэн утга санааг давхар илэрхийлжээ гэж үзэж болохоор байна.

Би үгүйн асуудалтай холбоотойгоор “бусдын эрхт” гэсэн ойлголт тайлбарлагдана. Мадхьямака философид “бусдын эрхт” гэдгийг «Шалтгаан нөхцөл бусдын эрхэнд шүтсэнээс гарсан бөгөөд огоот бүтсэний шүтээн болсон тэр бусдын эрхтийн бэлгэ чанар»³⁸ гэж тодорхойлсон байдаг. Эндээс үзэхэд нөхцлийн эрхээр гардаг буюу бусдад шүтэж, бусдаас хамааралтай үүсдэг аливаа юм нь бусдын эрхтийн бэлэг чанартай болж байна. Үүний утга нь аливаа юм *би үгүй* буюу онохуй, оногдохуй хоёрын харилцаанд үнэхээр бүтээгүй, өөрийн бэлгэ чанаргүйд өгүүлснийг давхар тодорхойлж байгаа хэрэг юм. Хэрэв юмсыг энэ байна,

³⁴ Tsepak Rigzin, “Tibetan-English Dictionary of Buddhist Terminology” (Revised and Enlarged Edition), 221 дэх тал

³⁵ Мөн тэнд. 17 дахь тал

³⁶ rTen 'brel snying bo'i dgongs 'grel. bsTan dar snags rams pa'i gsung bum, Kha боть, 5 дахь хуудас, дээд

³⁷ Grub mtha' rin chen phreng ba'i tshig 'grel thor bu. Бээжин, 1995, 114 дэх тал

³⁸ Мөн тэнд. 30 дахь тал

энэ буй хэмээвээс, тэгж танин бариваас тэр нь өөрөөс төрсөн буюу өөрийн эрхэт болно. Тиймээс энэ тухай «Тэр ямагт шинж тэмдгээр бүтвээс энэ мэт чухал авсан цогц, ном ч мөнх бус бөгөөд нөхцлөөс төрсөн орчлон мөний тулд ном тэр ч үйл хийгээд нисванис бусдын эрхэт өөрөө мөн байх албатай»³⁹, «Үйлээс нисванисаас төрсөн хийгээд агшин ч орших өөрийн эрхэт үгүй мөнх бус мөний тул тэр ном ч мөнх нэг өөрийн эрхтээр өөрөө мөн бус байх албатай»⁴⁰ гэж тайлбарласан байдаг. Энэ нь төрөхүй үнэхээр бүтсэн бус. Учир нь эгнэгт өөрөө төрсөн, байнга төрөөд байх юм гэж үгүй. Иймээс төрсөн, төрөөгүй хоёрын хоорондын харилцаа л байна. Юмс нь бусдаас төрсөн бус. Учир нь бусад гэсэн бие даасан юм байхгүй, бусад нь бие биеэс хамааралтай оршдог шүтэлцээ юм. Тэгэхээр бусдын эрхт болон өөрийн эрхт үнэхээр байж чадахгүй гэсэн санааг зохиогч тодорхойлон өгүүлжээ.

Буддын философийн өөрийнх нь арга зүйн үүднээс үзэхүл, гүн ухааны аливаа асуудал дээр эсрэг тэсрэг хоёр тал шинжийг гаргаж тавиад, гэхдээ тэдгээрийн аль нэгийг нь тогтоон барих биш, харин тэр хоёрыг хооронд нь шүтэлцүүлж, шинэ дээд байдлыг олж тодруулж байх ёстой гэж үзнэ. Энэ бол зөвхөн төв үзлийн гүн ухаанд биш, ерөөс буддын сэтгэхүйд өөрт нь шингэмэл байх анхдагч методологи нь юм гэж манай нэрт эрдэмтэн судлаачид тодорхойлсон байдаг. Тийм ч учраас буддын тогтсон тааллын чиглэл бүхэн энэхүү төв дундын зам мөрийг өөр өөрийнхөөрөө боловсруулан илэрхийлсэн байх бөгөөд түүнийг гүн ухааных нь үүднээс, тал бүрээс нь нарийвчлан боловсруулж, хэрэгжүүлсэн нь л төв үзлийн гүн ухаан болно. Дандар аграмба энэхүү буддизмын язгуур методологийн үүднээс асуудалд хандаж, бодас өөрийн чанараар бүтсэн гэвэл бие даан мөнхөд орших ба эвдрэхгүй, үнэхээр бүтсэн болно. Түүнийг эгнэгт байх зүйл мэтээр үзэхэд хүрнэ. Тиймээс байх, байхгүй; мөнх, тасархай; би, би бус зэргийн аль нэгийг нь байна хэмээн өрөөсгөлөөр авч үзэж болохгүй, гагцхүү тэр бүхнийг харьцангуйд барьж, тэдгээрийг бие биедээ харилцан шүтэлцэж шилжимтгий харилцаанд оршдог гэж үзжээ.

Тэрээр энэхүү шүтэн барилдлагын зарчим болон шалтгаан үрийн асуудлыг цааш нь «...Ном бүгд мөн чанараар үгүйг мөнхүү тодруулж номлосон бөгөөд ... мунхаг энэ буйн тул хуран үйлдэх энэ гарах бөгөөд үлгэрлэвээс зулнаас гарах гэрэл мэт болой»⁴¹ гэж шүтэн барилдлагын арван хоёр гишүүнээр тодруулан тайлбарлажээ. Дандар аграмба мунхгийг танин мэдэх олон янзын зам бий, төв үзэлтний ёсоор мунхаг гэдэг нь юмс өөрийн мөн чанараараа үнэхээр бүтээгүй атал бүтсэн гэж шуналтагч ухаан юм. Ийм мунхаг ухааны эрхээр бусад нисванисууд төрнө. Бид юмсыг үнэхээр бүтсэн гэж эндүүрэн ойлгодог оюун ухаанд ижилдэн дассан байдаг. Гэвч энэ нь зөв үзэл бус бөгөөд үүний эсрэг тал болох юмсын мөн чанар байхгүй болохыг онож мэдэх явдал чухал юм. Өөрөөр хэлбэл нэг талаас сэтгэлгээний хувьд хязгаарлагдмал мунхаг ухаан, нөгөө талаас юмс өөрийн мөн чанараараа бүтээгүйг онож мэдсэн оюун билиг хоёрын хандаж байгаа зоригдол /объект/ нь ижил байж болно. Харин тэдгээрийн тухайн үзэгдэл, үйл явцад хандаж байгаа үзэл баримтлал нь шууд эсрэг тэсрэг юм. Энэхүү ухаан билиг хүнд бүрэн төгс төрснөөр зоригдолд хандах танин мэдэхүйн үйл явц нь дээд түвшинд хүрч, оршихуй юмсыг өөрийн мөн чанараараа бүтсэн гэж төөрөлддөг мунхаг ухаан дарагдана. Өөрөөр хэлбэл оногдохуй болох вишайг үнэхээр бэлгэ чанараар бүтсэн гэж үзэх мунхагаас элдэв үйл, нисванис төрөх ба түүнээс элдэв зүйлийн зовлон, унал, доройтол бүхэн үүдэн гардаг. Харин вишайг өөрийн бэлгэ чанараар байхгүй гэдгийг оносон билиг оюунаар л вишайг өөрийн чанараар бүтсэн хэмээх би-г баригч мунхгийг буцаана. Тэр мунхгийг дарснаар түүнээс гарах зовлон бүхэн буцах учиртай ажгуу⁴².

³⁹ rTen 'brel snying bo'i dgongs 'grel. bsTan dar snags rams pa'i gsung bum, Kha боть, 5 дахь хуудас, дээд

⁴⁰ Мөн зохиол. 5 дахь хуудас, дээд

⁴¹ rTen 'brel snying bo'i dgongs 'grel. bsTan dar snags rams pa'i gsung bum, Kha боть, 7 дахь хуудас, доорд

⁴² Лувсанбалдан (Оргиочын лам), Бодьсадвын явдалд орохуй шастрын дугуйт тайлбар, Т.Булганы орчуулга, УБ., 2009, 327 дахь тал.

Дандар аграмба цааш нь «Ном нугууд бодтой өөрийн эрхт дор үл бүтэн бусдын шүтээнд адилтгаваас адхагын хүлээс төдийд бүтэхийн шүтээн гарах мэт номлох бөгөөд энэ буй энэ гарах мэт номлох бөгөөд энэ буй энэ гарах тэргүүтэн мэт болой»⁴³ хэмээн “адхагын хүлээс” гэдэг ойлголтыг гаргаж ирсэн байна. Адхагын хүлээс гэдэг нь энэ ертөнц, ертөнцийн юм үзэгдлийг үнэхээр бүтсэн хэмээн хүлээн зөвшөөрч, түүний улмаас бодтой оршин буй мэт үзэгдэх бүтэд шунаан хоргодох ташаа үзлээр оюуны мэлмий нь халхлагдаж, улмаар үнэмлэхүй үнэн, шүтэн барилдлага, хоосон чанарыг үл ухах төлөв байдлыг хэлнэ. Тиймээс аливаа бодгаль нь адхагын хүлээснээс ангижраагүй цагт юм үзэгдлийг өөрийн мөн чанараар үнэхээр бүтсэн хэмээн баримталж, улмаар орчлонгийн унал бүхэн гарах ажээ.

Буддын гүн ухаанд, тухайлаад төв үзлийн гүн ухаанд үзэхдээ *шалтгаан* гэж нэрлэж байгаа зүйл ч үнэхээр бүтээгүй, тэгэхээр тийм үнэхээр бүтээгүй юмнаас үр дагавар гарна гэж ч байхгүй болно. Юмс зөвхөн *бусдаас төрдөг бус*, зөвхөн *өөрөөс төрдөг бус*, *хоёулангаас бус* гэж тэр бүгдийг шүтэн барилдлагад нь *хоосон чанар* болгон үзсэн байна.

Дандар аграмба тус бүтээлдээ хэдийгээр *үнэхээр эс бүтэхүй* болон *шүтэн барилдахуйн* зарчмыг хөдөлгөөн, тоо, орон, цаг зэрэг бусад ойлголтуудаар, тэдгээрийн хоорондын харилцаагаар тодорхойлж гаргаагүй боловч *би* хийгээд *би* үгүй, *мөнх* хийгээд *мөнх бус*, *өөрийн эрхт* хийгээд *бусдын эрхт* зэрэг буддын философийн гол гол ойлголтуудыг хамруулж, улмаар аливаа юмс өөрийн чанараар үнэхээр бүтээгүй учир хувьсах харьцаанд орших талаар өөрийн үндэслэлүүдээ дэвшүүлсэн нь бэлхнээ харагдаж байна. Ийнхүү бүгдийг шүтэн барилдсан, бие биедээ байнгад харилцан шилжиж байх, иймээс нэг байдлаар тогтоон үзэж үл болох харилцаанд харьцангуй шинжтэй оршино гэсэн төв үзлийн философийн нэг гол үндэслэлийг тус бүтээлдээ тусган харуулжээ.

Ашигласан материал

1. rTen 'brel snying bo'i dgongs 'grel. bsTan dar snags rams pa'i gsung bum, Kha боть, Гандантэгчэнлин хийдийн номын сан
2. Ж.Болдбаатар, “Далай ламын монгол багш”, УБ., 1995
3. bsTan dar snags rams pa'i gsung bum, Ka, Kha, Ga боть, Гандантэгчэнлин хийдийн номын сан
4. Bu ston rin chen grub, *Bu ston chos 'byung*, Drepung Loseling Library Society, Delhi: 1996
5. Д.Дагвадорж, “Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг”, УБ., 1998
6. Ц.Дамдинсүрэн, “Ганжуурын төвд хэвлэлүүдэд хийсэн Дандар аграмбын ариутгал” – Монгол судлал, Том IX (17), Fasc. 2, УБ., 1982
7. Ц.Дамдинсүрэн, “Өвгөн Жамбалын яриа”, Түүвэр зохиол, УБ., 1969
8. Grub mtha' rin chen phreng ba'i tshig 'grel thor bu. Бээжин, 1995
9. Г.Лувсанцэрэн, “Төв үзлийн философийн онолын үндэс”, УБ., 2006
10. “Лавайн эгшиг”, бурхан шашны судлал, мэдээллийн сэтгүүл, УБ., 1996, № 2
11. Лувсанбалдан (Оргиочын лам), Бодьсадвын явдалд орохуй шастрын дугуйт тайлбар. Т.Булганы орчуулга, УБ., 2009
12. Монголын философийн түүх, IV дэвтэр, УБ., 2001
13. “Хутагт тааллыг магад таалахуй”, Монгол Ганжуур, 64 дүгээр боть, YHC
14. Tsepak Rigzin, “Tibetan-English Dictionary of Buddhist Terminology” (Revised and Enlarged Edition)

⁴³ rTen 'brel snying bo'i dgongs 'grel. bsTan dar snags rams pa'i gsung bum, Kha боть, 7 дахь хуудас, дээд